



ТАХЬКО (ХК) КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2014 оны 1 сарын 20 өдөр

Дугаар 01

Улаанбаатар

Тахько (ХК) компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал 2014 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 09.05 цагт компанийн хурлын 303 тоот өрөөнд эхлэв. Хуралд Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Л.Буянбат, гишүүн Ш.Мөнх-Очир, Л.Батбилэг, С.Итгэл, Б.Бямбасүрэн, Л.Энхнасан, Л.Галбадрах Т.Тамир, Б.Батхуяг нар оролцов. Хурлын ирц 100 хувь байв. Хурлыг Л.Буянбат даргалав.

Хурлаар дор дурдсан асуудал хэлэлцэв. Үүнд:

1. Ньютел компанитай байгуулсан түрээс, үйлчилгээний гэрээний хугацаа дуусах болж байгаатай холбогдуулан компанийн Гүйцэтгэх удирдлагад өгөх чиглэлийн тухай.
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн Аудитын, Нэр дэвшүүлэх, Цалин урамшууллын болон Нарийн бичгийн даргын үйл ажиллагааны журмын төслийг хэлэлцэж батлах.

Нэгдүгээр асуудал.

Л.Буянбат: Тахько (ХК) компани Ньютел (ХХК) компанитай 2004 онд 10 жилийн хугацаагаар байгуулсан түрээс, үйлчилгээний гэрээний хугацаа энэ оны 07 дугаар сард дуусгавар болж байгаа юм. Эдгээр гэрээг цааш нь үргэлжлүүлж сунгах уу, шинээр байгуулах уу гэсэн асуудлыг урьдчилан ярилцах шаардлагатай байгаа юм. Гүйцэтгэх удирдлагын зүгээс 2013 онд Ньютел компанитай хэд хэдэн удаа ярилцаж байсан. Ньютел компанийн зүгээс тавьсан саналын дагуу компанийн үл хөдлөх хөрөнгийг цаашид үргэлжлүүлэн түрээслэх талаар санамж бичиг үйлдэж гарын үсэг зурсан байгаа. Ньютел компанийн Гүйцэтгэх захирлаар Нарантуяа гэдэг хүн сүүлд томилогдон ажиллаж байгаад ажлаа өгч өөрчлөгдсөн. Өнөөдрийн байдлаар гэрээний асуудлаар хэнтэй харьцах нь тодорхойгүй байгаа. Ньютел компани нь Мобиком компанийн 100 хувийн хөрөнгө оруулалттай охин компани байгаа. Мобиком компанийн өмнөх удирдлага өөрчлөгдөж, Гүйцэтгэх захирлаар шинээр Дэвид Холлидэй гэдэг гадаадын хүн томилогдсон. Энэ хүнтэй уулзах хүсэлтийг өнгөрсөн оны 12 дугаар сард бичгээр явуулсан боловч уулзалт хийх товоо өгөөгүй учир уулзаагүй байна. Өнөөдрийн ярих гол асуудал бол түрээсийн гэрээг сунгах ч бай, шинээр хийх ч бай компанийн зүгээс ажлын хэсэг байгуулж, гэрээг шинэчлэхтэй холбогдсон судалгаа хийж байх нь зөв байх гэж бодож байна. Ажлын хэсэг юу хийж бэлтгэх, ямар мэргэжлийн хүмүүс байвал зохистой вэ гэсэн асуудлыг хэлэлцэх санал оруулж байна. Ажлын хэсэгт эдийн засагч, бизнесийн чиглэлийн эрх зүйч мэргэжлийн хүмүүсийг ажиллуулах шаардлагатай гэж үзэж байна. Ажлын хэсэгт хүмүүс ажиллуулж байгаа учир цалин, зардал гарах байх. Энэ зардлын төсвийг тогтоож батлуулах хэрэгтэй байх.

Л.Энхнасан: Зардлын асуудлыг өнөөдөр ярилцахгүйгээр үлдээж, ажлын хэсгээ байгуулах нь зөв байх. Ажлын хэсэг зардлаа төлөвлөөд батлуулах нь зөв болуу. Мобиком компани бүтцийн өөрчлөлт хийж байгаа юм байна. Энэ өөрчлөлтөөр Ньютел компани байх эсэх нь мэдэгдэхгүй, шийдэгдээгүй байгаа юм байна. Хэрэв Ньютел компани татан буугдаад Мобикомын бүтцэд багтан орвол бид Мобиком компанитай гэрээ хийх болно. Манайх өнөөдрийн байдлаар Ньютел компанитай түрээсийн гэрээ шинэчлэх, түрээсийн үйлчилгээний төлбөрийг зах зээлийн өнөөгийн хэмжээнд хүргэх, үйлчилгээний гэрээг үйлчилгээний, ашиглалтын гэрээ гэж тусдаа хоёр гэрээ байгуулах, үндсэн хөрөнгө байрыг нийтэд нь нэг гэрээгээр түрээсэлж байгааг өөрчилж, байр тус бүрт нь гэрээ байгуулах, гэрээний хугацааг богино болгох, инфляцийн өөрчлөлтөөс хамаараад түрээсийн төлбөрт тухай бүрт нэмэлт, өөрчлөлт оруулж байх асуудлаар ярилцаж, урьдчилсан тохиролцоонд хүрээд байсан. Бидний мэдээллээр Мобиком компани нь тусдаа ажлын хэсэг томилон энэ асуудлаар судалгаа, дүн шинжилгээ хийж байгаа боловч Ньютел компанийн улирлалаа өөрчлөвчлөн энэ компани бие лаасан байллаар байх

эсэх нь шийдэгдээгүй тул Мобиком компанийн удирдлагатай уулзаж ярилцахаар хүсэлтээ хүргүүлээд байгаа болно. Иймд бидний зүгээс мөн адил ажлын хэсэг байгуулаад бэлтгэл судалгаа хийж өөрсдийн бэлтгэлээ хангах шаардлагатай болж байгаа юм. Ажлын хэсэгт гадны хүмүүс ажилуулах, эдийн засагч, үл хөдлөх хөрөнгөөр дагнасан ажлын дадлагатай хүн, хуучин гэрээг хийхэд оролцож байсан хүмүүсээс оролцуулах бодолтой байна. Би тухайн үед гэрээ хийхэд Ньютел компаниас гардан оролцож байсан Баасансүрэнтэй уулзаж амаар тохиролцоод байгаа. Бид ганцхан Ньютел, Мобикомтой биш Скайтел, Юнител компанитай шууд бус байдлаар харьцах хэлбэрээр өөр түрээслэгч сонгох судалгаа ч хийж болох байх. Өөр нэг асуудал бол энэ жилийн төлөвлөгөө хагас жилээр хийхээр төлөвлөж байна. Эхний хагас жилийнхийг одоогийн мөрдөж байгаа гэрээ хэлцлийн үндсэн дээр, дараагийн хагас жилийн төлөвлөгөөг гэрээ хэлцэл байгуулагдсаны дараа хийх нь зөв юм болов уу гэж төлөвлөж байна.

Б.Батхуяг: Ажлын хэсэгт оруулах хүний санал байна уу.

Л.Буянбат: Цэгц компанид ажиллаж байсан Баасансүрэн гэж хүн байгаа.

Л.Энхнасан: Ажлын мэдлэг туршлагатай бас нэг хүн байгаа.

Б.Батхуяг: Ажлын хэсэг ямар хугацаанд яаж ажиллах вэ.

Л.Энхнасан: Тодорхой хугацаанд төлөвлөгөө гаргаад ажиллуулъя гэсэн санал байна.

Л.Галбадрах: Ажлын чиг юу байна, их өндөр өртөгтэй хүн ажиллуулах шаардлага байна уу. Мобикомын хийсэн хөрөнгө оруулалтыг яах вэ.

Л.Энхнасан: Ажлын хөлс гайгүй болно. Хийсэн хөрөнгө оруулалтыг өгч авах, яаж хүлээж авах тухай тодорхой заалт гэрээнд тусгагдаагүй. Аман яриагаар бол оруулсан хөрөнгө оруулалтыг өгнө гэсэн байдаг.

Б.Батхуяг: Иргэний хуулинд түрээслэгч, түрээслүүлэгч гэрээгээр түрээслэгчийн оруулсан хөрөнгө оруулалтыг өгөх авах талаар гэрээнд тусгана. Хэрэв энэ талаар ямар заалт гэрээнд байхгүй бол оруулсан хөрөнгө оруулалтыг буцааж авахгүй гэсэн зохицуулалт байдаг. Тийм учраас түрээслүүлэгч буцааж өгөх үүрэг байхгүй, нөгөө тал нэхэмжлэх эрх байхгүй юм. Хугацаанаас нь өмнө гэрээг цуцалсан тохиолдолд үнийг төлнө.

Б.Батхуяг: Ажлын хэсэг зах зээлийн үнийн судалгаа гаргах өөр ямар үүрэгтэй байх вэ.

Л.Энхнасан: Зах зээлийн үнийн судалгаа гаргана, гэрээний төслийг гаргана, өөр бусад шаардлагатай нөхцлүүдийг тодорхойлно. Үүнийг нь Төлеөлөн удирдах зөвлөл дээр ярилцаад шийдэх юм.

Л.Галбадрах: Сунгая гээд тохиролцсон нөхцөлд драфтаа гаргаад нөгөө талдаа өгч санал солилцох байдлаар хийх нь зөв байх. Драфтаа аль тал гаргах вэ.

Л.Энхнасан: Драфтаа манайх гаргана. Тиймээс ажлын хэсгээр хийлгэсэн судалгаа хэрэгтэй. Нөгөө талыг харах биш бид өөрсдөө юмаа хийгээд шахах хэрэгтэй байна. Тэгэхгүй бол хугацаа нь тулаад шахалтанд орж болзошгүй гэж үзэж байна. Юмыг яаж мэдэхэв цаг нь тулаад ирэхээр түрээслэхээ болилоо ч гэх юмуу асуудал гарч ирвэл хэцүү болно. Иймд бид судалгаагаа хийгээд драфтаа гаргахад хугацаа алдмааргүй байна.

Л.Галбадрах: Ер нь өөр түрээслэгч сонирхож үзэв үү, судалж үзэх хэрэгтэй. Дараа нь гэрээ хийхэд хэрэг гарч болно шүү, бас гэрээ хийхэд дөхөмтэй болно. Иймд тийм мессэж нисгэх хэрэгтэй. Эд нар бол түрээсээ үргэлжлүүлэхгүй гэхгүй нь ойлгомжтой, хугацааг дөхүүлээд хямд хөнгөлттэй нөхцлөөр тулгаж байгаад гэрээ хийх бодолтой байж магадгүй. Иймд төслөө гаргаж өгчихөөд өөр түрээслэгчтэй ярилцах замаа нээлттэй орхих хэрэгтэй.

Б.Батхуяг: Судалгаа хийж, гэрээний нөхцлөө гаргаад өгье, өгөхдөө хугацаа зааж өгье, тэр хугацаанд хариу өгөхгүй бол бид өөр түрээслэгчид хандах тухай ойлголт шаардлага хүргүүлчихвэл ямар вэ. Тэгвэл нөгөө тал ч шуурхай болох байх.

Л.Галбадрах: Аль болох эртнээс яриа хэлцэлд орох замаа нээх хэрэгтэй.

Б.Бямбасүрэн: Гэрээгээ урт хугацаагаар хийгээд үнийн өсөлттэй холбогдуулан төлбөрийн нөхцөлд жил тутам өөрчлөлт оруулж байхаар хиймээр юм шиг байна. Барилгын компаниуд гэрээндээ инфляцийн өсөлттэй уялдуулна гэсэн заалт хийдэг юм байна лээ.



Л.Энхнасан: Түрээсийн үнэн дээр бодолцох юм байгаа, давхар өөр байх, нийтийн талбай гэж байна, ашиглуулж байгаа талбай байдаг, мөн давхар түрээсийн асуудал гэх мэт.

С.Итгэл: Ажлын хэсэг яг юу хийх вэ, гэрээгээр ажиллах байх, ажлын удирдамж чиглэл тодорхой байх хэрэгтэй.

Ш.Мөнх-Очир: Ашиглалтын тооцоо, инженерийн байгууламжийн зардал гээд өөрөөс гарах судалгаа шаардлагатай болох байх.

Л.Энхнасан: Манай инженерүүд судалгаа хийж гаргаж байгаа, зарим судалгаа тухайлбал тариф, хэрэглээний тооцоо гарчихсан байгаа. Үүн дээр үндэслээд квадрат метр нь ямар үнэлгээтэй болохыг эдийн засагч гаргах хэрэгтэй болж байгаа юм.

Б.Батхуяг: Ажлын хэсгийг цөөхөн хүнтэй байгуулах хэрэгтэй. Ер нь 3 хүний бүрэлдэхүүнтэй байвал болох байх.

Л.Энхнасан: Ажлын хэсгийг 4 хүнтэй байлгамаар байна.

С.Итгэл: Гүйцэтгэх захирал мэдээллээр хангах боломжтой ажлын хэсэгт багтахгүйгээр ажлын хэсэгтэй хамтарч ажиллаад, ажлын хэсэг 3 хүнтэй байвал болох уу.

Л.Буянбат: Ажлын хэсэгт ямар мэргэжлийн хүмүүс оруулах, хэдийд байгуулахыг Гүйцэтгэх захиралд үүрэг болгож өгье. Энэ 7 хоногт ажлын хэсэгт орох хүмүүсийг сонгож, ажлын хэсгийг томилох шийдвэр, хийх ажлын чигийг батлуулах чиглэл өгөх санал оруулж байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаас ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Ажлын хэсгийг Гүйцэтгэх захирал удирдах, түүний бүрэлдэхүүнийг Гүйцэтгэх захирлаас гадна 3 хүний бүрэлдэхүүнтэй байгуулах шийдвэр гаргуулах, ажлын хэсгийн гүйцэтгэх ажлын удирдамж чиглэлийг гаргаж батлуулах үүргийг Гүйцэтгэх захирал Л.Энхнасанд өгөв.

Хоёрдугаар асуудал:

Л.Буянбат: Төлөөлөн удирдах зөвлөлийн Аудитын, Нэр дэвшүүлэх, Цалин урамшууллын болон Нарийн бичгийн даргын үйл ажиллагааны журмын төслийг хэлэлцэж батлах асуудал байгаа. Төслийг мэйлээр явуулсан, саналууд гүйцэд ирээгүй тул дахин сайн судалж саналаа ирүүлсний дараа хэлэлцэх саналтай байна.

Л.Энхнасан: Сайн судалж, саналаа гаргасны дараа дараагийн хурлаар хэлэлцэх саналтай байна. Та бүхэн сайн судалж, саналаа ирүүлээрэй.

Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаас ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Төлөөлөн удирдах зөвлөлийн Аудитын, Нэр дэвшүүлэх, Цалин урамшууллын болон Нарийн бичгийн даргын үйл ажиллагааны журмын төслийг Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд саналаа гүйцэд ирүүлсний дараа, дараагийн хурлаар хэлэлцэхээр хойшлуулав.

Л.Буянбат: Гүйцэтгэх захирлаар ажиллаж байсан Ж.Чимэдцэрэнгээс ажлаас чөлөөлөгдсөнөөс хойших хугацааны цалин урамшуулал олгож өг гэсэн асуудлыг бичгээр ирүүлсэн. Цалингаас гадна урамшуулал, амралтын мөнгө ч олгуулах асуудал тавьсан байна лээ. Асуудлыг Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын нэр дээр ирүүлсэн боловч хурлаар хэлэлцэх нь зүйтэй гэж үзэж байна. Үүнийг ойрын үед хэлэлцэж хариуг өгөх юм. Ж.Чимэдцэрэнг ажлаа хийхийг мэдэгдсэн боловч ажлаа хийгээгүй учир Төлөөлөн удирдах зөвлөл бүрэн эрхийн хүрээнд 2013 оны 07 дугаар сард ажлаас нь чөлөөлсөн шийдвэр гаргаад өөрт нь хүргүүлчихсэн байгаа. Ямар ч байсан цалин хөлс олгох эсэхийг хурлаар хэлэлцэж шийдвэрлэх хэрэгтэй гэж үзэж байна. Ирүүлсэн шаардлагыг нь мэйлээр гишүүдэд явуулна. Тэгээд дараагийн хурлаар хэлэлцье.

Б.Батхуяг: Хэлэлцэх асуудалд ороогүй боловч Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Л.Энхнасанг Гүйцэтгэх захирал болгох асуудлыг нэмэлт асуудал болгон хэлэлцүүлэх санал оруулж байна.



Л.Буянбат: Б.Батхуягийн санал болгож байгаа нэмэлт асуудлыг хэлэлцэх эсэх тухай санал явуулахад хуралд ороолцож байгаа гишүүд 100 хувийн саналаар хэлэлцэхийг зөвшөөрсөн санал гаргав.

Б.Батхуяг: Л.Энхнасан компанийн Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгчээр жил гаруй хугацаагаар ажилласан, өмнөх захирал албан ёсоор чөлөөлөгдсөн, компанитай холбоотой томхон гэрээ хэлцэл байгуулах болж байна, ийм нөхцөлд үүрэг гүйцэтгэгч биш албан ёсны сонгогдсон захиралтай байх хэрэгтэй зэргээс түүнийг Гүйцэтгэх захирлаар сонгож томилох санал оруулж байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаас ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Хуралд оролцож байгаа гишүүдийн 100 хувийн саналаар Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Л.Энхнасанг Гүйцэтгэх захирлаар сонгож, томилох шийдвэр гаргахаар шийдвэрлэв.

Хэлэлцэх асуудал дууссан тул хурлыг 10.19 цагт хаав.

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН

ТАНИЛЦСАН ТУЗ-ИЙН
ДАРГА


ГИШҮҮН


Ц.ДОРЖГОТОВ


Л.БУЯНБАТ


Л.БАТБИЛЭГ


Б.БАТХУЯГ


Б.БЯМБАСҮРЭН


Л.ГАЛБАДРАХ


Т.ТАМИР


Ш.МӨНХ-ОЧИР


С.ИТГЭЛ


Л.ЭНХНАСАН

